

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 8 сарын 08 өдөр

Дугаар 248

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах
хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дах заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ журам батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 199 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас хаалттай өрийн бичиг гаргах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ГАРГАХ ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧГИЙГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Банк бус санхүүгийн байгууллага /цаашид “ББСБ” гэх/- аас гаргах хаалттай өрийн бичгийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хаалттай өрийн бичиг гаргахад тавигдах шаардлага

2.1. Хаалттай өрийн бичиг гаргах ББСБ нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг хангасан байх;

2.1.2. Хорооноос тогтоосон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 4 улирал дараалан хангаж ажилласан байх;

2.1.3. Хаалттай өрийн бичгийг бүртгүүлэх хүсэлттэй холбогдуулан Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалттай үнэлгээ авч, санхүү, төлбөрийн чадварын хувьд уг өрийн бичгийг гаргах боломжтой гэж дүгнэгдсэн;

2.1.4. сүүлийн жилийн тайлант хугацааны эцэст ашигтай ажилласан байх;

2.1.5. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад.

2.2. ББСБ-аас гаргах хаалттай өрийн бичиг нь 12 сар хүртэлх хугацаатай байх бөгөөд Хорооноос олгосон банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дуусах хугацаанаас хэтэрч болохгүй.

2.3. Хаалттай өрийн бичиг гаргагч ББСБ болон уг өрийн бичгийг эзэмшигч талууд тухайн хаалттай өрийн бичигтэй холбоотойгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглах зэрэг аливаа хэлбэрээр нийтийг хамарсан мэдээлэл түгээж, зар сурталчилгаа явуулахыг хориглоно.

2.4. ББСБ нь хаалттай өрийн бичгийг тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны хүрээнд тухайлсан зориулалт, нөхцөл бүхий багцаар гаргаж болно.

2.5. ББСБ-аас гаргах хаалттай өрийн бичиг нь өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

2.6. */Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 346 дугаар тогтоолоор хассан/*

2.7. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ нь Монгол улсын иргэн, хуулийн этгээдээс хаалттай өрийн бичиг гаргах замаар мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлэхийг хориглоно.

2.8. Хорооны шийдвэрээр ББСБ-аас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэхийг зөвшөөрсөн нь Хороо түүнээс үүсэх аливаа үр дагавар, эрсдэлийг хүлээх үндэслэл болохгүй.

Гурав. Хаалттай өрийн бичгийг бүртгэх

3.1. ББСБ нь хаалттай өрийн бичиг бүртгүүлэх хүсэлтээ Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг заавал ирүүлнэ:

3.1.1. ББСБ-ын Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан хаалттай өрийн бичиг гаргах тухай шийдвэрийн эх хувь;

3.1.2. ББСБ-ын хаалттай өрийн бичигтэй холбоотой зохицуулалтыг тусгаж, баталсан дүрмийн эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хувь;

3.1.3. ББСБ-ын хаалттай өрийн бичгийн зориулалт, хэлбэр, хэмжээ, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, үүсч болзошгүй эрсдлийг гэрээний талууд хэрхэн хариуцах тухай болон бусад нөхцөл, эдийн засгийн үндэслэл бүхий үр ашгийн тооцоозэрэг мэдээллийг тусгасан танилцуулга;

3.1.4. ББСБ-аас гаргах хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээний төсөл;

3.1.5. ББСБ-ын жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон татварын байгууллагаар баталгаажуулсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан;

3.1.6. Хорооноос шаардсан бусад баримт бичиг.

3.2. ББСБ-ын хаалттай өрийн бичгийг бүртгэх тухай шийдвэрт заасан хугацаанд тухайн хаалттай өрийн бичгийн арилжаалагдаагүй үлдэгдлийг арилжаалахыг хориглох тухай шийдвэрийг гаргах тохиолдолд Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

Дөрөв. Хаалттай өрийн бичгийг бүртгэхээс татгалзах, бүртгэлээс хасгах

4.1. Хороог төлөөлөн Хорооны ажлын албанаас дараах үндэслэлээр ББСБ-ын хаалттай өрийн бичгийг бүртгэхээс татгалзаж энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ:

4.1.1. баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл хуурамч мэдээ, баримт ашигласан нь илэрсэн;

4.1.2. энэхүү журмын 2.1-д заасан шаардлагын аль нэгийг хангаагүй;

4.1.3. өрийн бичиг гаргахтай холбогдуулан ББСБ нь нийтэд мэдээлэл цацаж, сурталчилгаа хийсэн нь тогтоогдсон;

4.1.4. холбогдох хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон.

4.2. ББСБ-ын хаалттай өрийн бичгийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд татгалзсанаас хойш 1 жилээс доошгүй хугацааны дараа хүсэлтийг дахин хүлээн авч болно.

4.3. Шаардлагатай гэж үзвэл хаалттай өрийн бичиг эзэмшигчийн гуравдагч этгээдэд хаалттай өрийн бичгээ худалдах зэргээр эзэмших эрхээ шилжүүлэхийг Хорооны хуралдааны шийдвэрээр хязгаарлаж болно;

Тав. Хаалттай өрийн бичиг гаргагч ББСБ-ын эрх, үүрэг

5.2. Хаалттай өрийн бичиг гаргагч ББСБ дараах эрх үүрэгтэй:

5.2.1. Хорооноос тогтоосон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллах;

5.2.2. өрийн бичиг гаргах замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны хүрээнд зөвхөн хаалттай өрийн бичиг гаргах танилцуулга, хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах;

5.2.3. хаалттай өрийн бичиг худалдан авагчдад өөрийн үйл ажиллагааны талаар худал ташаа мэдээ, мэдээлэл өгөхгүй байх, хаалттай өрийн бичиг эзэмшигчийн хүсэлт, шаардлагын дагуу шаардлагатай, үнэн зөв мэдээллээр хангах;

5.2.4. олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэбсайтаар хаалттай өрийн бичиг гаргахтай холбогдуулан мэдээлэл тараах, сурталчилгаа явуулахгүй байх;

5.2.5. хаалттай өрийн бичиг эзэмшигчтэй хаалттай өрийн бичгийг худалдах, худалдан авах гэрээг байгуулж нотариатаар баталгаажуулах;

5.2.6. Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу хаалттай өрийн бичиг эзэмшигчид, тэдгээрийн талаар дэлгэрэнгүй бүртгэлийг үнэн зөв хөтөлж, тайлан гаргаж улирал бүр Хороонд ирүүлж байх;

5.2.7. хаалттай өрийн бичиг эзэмшигчийн гуравдагч этгээдэд өрийн бичгийг худалдах зэргээр эзэмших эрхээ шилжүүлсэнтэй холбоотой мэдээллийг нэн даруй Хороонд ирүүлэх;

5.2.8. энэ журмын хавсралтын дагуу гаргасан “ББСБ-ын өрийн бичгийн бүртгэлийн тайлан”-г улирал бүрийн санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлэх;

5.2.9. хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

5.3. Хаалттай өрийн бичиг гаргагч ББСБ нь хаалттай өрийн бичиг эзэмшигч бүрт дараах баримт бичгээс бүрдсэн хувийн хэрэг бүрдүүлсэн байна:

5.3.1. хаалттай өрийн бичгийн танилцуулга, эдийн засгийн үндэслэл бүхий үр ашгийн тооцоо;

5.3.2. хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ /шаардлагатай бол гэрээний хавсралт баримт бичгүүдийн хамт/;

5.3.3. хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээний дагуу хийгдсэн гүйлгээний касс, мемориалын баримтууд;

5.3.4. Хаалттай өрийн бичиг эзэмшигчийн талаарх товч мэдээлэл /анкет/;

5.3.5. Шаардлагатай бусад баримт бичиг, мэдээллүүд;

Зургаа. Хаалттай өрийн бичиг эзэмшигчийн эрх, үүрэг

6.1. Өрийн бичиг эзэмшигч нь дараах эрх үүрэгтэй:

6.1.1. хаалттай өрийн бичгийг худалдах, худалдан авах гэрээний хугацаа дуусмагц үндсэн төлбөрийг хүүгийн хамт гэрээнд заасан дүнгээр эргүүлэн авах;

6.1.2. хаалттай өрийн бичиг гаргасан ББСБ-тай харилцан тохиролцсоны үндсэн дээр гуравдагч этгээдэд өөрийн эзэмшлийн хаалттай өрийн бичгийг худалдах зэргээр эзэмших эрхээ шилжүүлэх;

6.1.3. ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын байдлыг илэрхийлэх санхүүгийн тайлан, бусад мэдээлэлтэй танилцах, ББСБ-ын нууцлалын зэрэглэлтэйгээс бусад шаардлагатай гэж үзсэн мэдээллээр хангагдах;

6.1.4. хаалттай өрийн бичиг гаргах ББСБ-тай байгуулах гэрээнээс үүсч болзошгүй эрсдлийг урьдчилан тооцоолж дүгнэлт хийх;

6.1.5. гаргасан хаалттай өрийн бичиг нь Хороонд бүртгэгдсэн ББСБ-ын өрийн бичгийг худалдах, худалдан авах гэрээг байгуулж нотариатоор баталгаажуулах;

6.1.6. хууль тогтоомж болон хаалттай өрийн бичиг гаргагчтай байгуулсан гэрээнд заасан бусад эрх үүрэг.

Долоо. Өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ байгуулах

7.1. ББСБ-аас гаргасан хаалттай өрийн бичгийг бүртгэх Хорооны шийдвэрийг үндэслэн хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээг бусад этгээдтэй бичгээр байгуулж нотариатаар баталгаажуулна.

7.2. Өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээнд дараах зүйлийг зайлшгүй тусгасан байна:

7.2.1. ББСБ-ын нэр, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, хаяг;

7.2.2. худалдан авагч нь иргэн бол түүний овог нэр, иргэний үнэмлэхний болон регистрийн дугаар, хаяг, утас, e-мэйл хаяг;

7.2.3. худалдан авагч нь хуулийн этгээд бол түүний нэр, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, хаяг, утас, тухайн хуулийн этгээдийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны овог нэр, иргэний үнэмлэхний болон регистрийн дугаар, хаяг, утас;

7.2.4. хаалттай өрийн бичгийн зориулалт, хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хуваарь, хугацаа;

7.2.5. нэг удаагийн үйлдлээр бүрэн төлөгдөх, эсхүл хэсэгчлэн, хуваарийн дагуу төлөгдөх нөхцөл, хэлбэр;

7.2.6. хаалттай өрийн бичиг гаргах ББСБ нь хаалттай өрийн бичиг эзэмшигч өөрийн эзэмшлийн хаалттай өрийн бичгийг гуравдагч этгээдэд худалдах зэргээр эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулан тухайн гуравдагч этгээдтэй гэрээ байгуулахдаа анхны өрийн бичиг эзэмшигчтэй байгуулсан гэрээнд тусгасан зориулалт, нөхцлийг өөрчлөхгүй байх зарчмыг баримтлах;

7.2.7. өрийн бичигтэй холбоотой аливаа эрсдлийг гэрээний талууд бүрэн хариуцаж шийдвэрлэх талаар;

7.2.8. хаалттай өрийн бичиг нь өөр компаниас тусгайлан гаргасан баталгаатай эсэх;

7.2.9. хаалттай өрийн бичгийн гэрээгээр төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн авах үндэслэл, тавигдах нөхцөл, шаардлага;

7.2.10. хаалттай өрийн бичиг эзэмшигчийг холбогдох мэдээллээр хэрхэн хангах;

7.2.11. гэрээ байгуулсан өдрөөс эхлэн өрийн бичгийн хугацаа тоологдож эхлэх, гэрээний үргэлжлэх хугацаа, түүний дуусгавар болох нөхцөл;

7.2.12. бусад.

Найм. Хяналт, хариуцлага

8.1. ББСБ-аас хаалттай өрийн бичиг гарган энэхүү журмыг хэрхэн мөрдөж ажиллаж буйд Хороо хяналт тавих бөгөөд шаардлагатай гэж үзвэл ББСБ-ын үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж, ББСБ нь энэхүү журмыг зөрчсөн, цаашид үйл ажиллагаанд нь эрсдэл үүсч болзошгүй гэж үзвэл банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авна.

8.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Компанийн тухай болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

... ооОоо...

